



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/97


Сүхбаатар сум

“Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.5 “в”, 29.1.6 “а”, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.1, 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 102 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтэд өндөр хурдацтай тархаж байгаа “COVID-19”-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн төв Сүхбаатар суманд байрлах “Үйлчилгээний нэгдсэн төв”-д үйл ажиллагаа явуулж буй аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Сүхбаатар сумын 4 дүгээр баг, Төрийн банк, “Миг даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, үнэт цаасны “Масдак” ХХК, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо”-ны төлөөлөл зэрэг байгууллагуудын албан хаагчдын ажлын цагийг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд 09.00-14.00 байхаар тогтоосугай.
2. Цагийн хуваарьт өөрчлөлт орж буйтай холбогдуулан албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг дээрх байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ